



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 31 болон 32 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 08-р сарын 06-наас 08-р сарын 27-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 13 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Atradius байгууллагын 8-р сард шинэчлэн зарласан төсөөллөөр **дэлхийн эдийн засаг энэ онд 6.2 хувиар, ирэх онд 4.7 хувиар өсөхөөр** байна. Хөгжингүй орнууд хүн амын дийлэнх хувийг вакцинжуулаад байгаа бол эрчимтэй хөгжиж буй орнуудад вакцинжуулалтын хувь харилцан адилгүй байна. 2021 оны турш вакцинжуулалтын аян үргэлжилж, хөл хорио шат дараатай сулран, үйлчилгээний салбарууд сэргэснээр хэрэглээ нэмэгдэж, дэлхийн эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэхээр байна. Инфляцын дарамт нэмэгдэж байгааг үл харгалзан төв банкууд мөнгөний бодлогын төлөвөө сул хэвээр хадгалах төлөвтэй бол төсвийн дэмжлэг, багц хөтөлбөрүүдийн тодорхой хувь нь энэ ондоо үргэлжлэн хэрэгжихээр байна.

Харин шинээр гарч буй мутацад орсон вирусийн тархалт өсөлтийг сааруулж болзошгүй гол эрсдэл болж байна.

- Харин Conference board байгууллагын 8-р сард шинэчлэн зарласан төсөөллөөр **дэлхийн эдийн засаг энэ онд харьцангуй бага буюу 5.2 хувиар, ирэх онд 4.0 хувиар өсөхөөр** байна. Тус байгууллагаас дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүдэд 1) мутацад орсон вирусийн шинэ давалгаа бий болох 2) инфляцын өсөлттэй холбоотойгоор дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ, хөдөлмөрийн захад гажуудал үүсэх 3) инфляцыг хяналтад оруулах зорилгоор төв банкууд бодлогын төлөвөө эрт чангаруулж, энэ нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлах зэргийг онцолжээ.

**Хүснэгт 1. Дэлхийн санхүүгийн байгууллага, олон улсын агентлагуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд (хувиар)**

	Байгууллагуудын нэрс	Төсөөлөл хийсэн огноо	2021 он			2022 он	
			Дэлхийн эдийн засгийн өсөлт	БНХАУ	АНУ	Евро бүс	Дэлхийн эдийн засгийн өсөлт
1	Conference board	8/10/2021	5.2%	8.8%	6.0%	4.5%	4.0%
2	Atradius	8/19/2021	6.2%	8.4%	7.0%	5.0%	4.7%

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд



- McKinsey байгууллагаас 8-р сарын 20-ны нийтлэлдээ **олон улсын ачаа тээврийн үнэ огцом өссөн** талаар тайлбарлажээ. Вакцинжуулалт хийгдэж, хөл хорио суларсан нөлөөгөөр АНУ, Евро бүсийн хэрэглээ хурдтай сэргэсэн нь импортын бараа, бүтээгдэхүүн болон олон улсын тээврийн эрэлтийг өсгөн, дэлхийн томоохон боомтууд дээр контейнерын түгжрэл бий болох, сул контейнерын хомсдол үүсэх, улмаар тээврийн зардал хурдтай нэмэгдэх суурь шалтгаан болжээ. Нөгөө талаас, БНХАУ КОВИД-19-ийн дельта вирусээс сэргийлэх бодлогын хүрээнд боомтуудын хяналт, шалгалтыг чангаруулж, зарим боомтын үйл ажиллагааг түр зогсоосон нь олон улсын ачаа тээврийн боомтын хүчин чадлыг хязгаарлаж, түгжрэл үүсэхэд нөлөөлсөн байна. Улмаар Ази-Европ, Ази-АНУ хооронд нэг контейнер тээвэрлэх өртөг цар тахлын өмнө 2000 ам.доллар байсан бол энэ оны 8-р сард 12000 ам.доллар хүрч өсөөд байна. Баярын улирал эхэлж байгаа тул ойрын хугацаанд эрэлт өндөр хэвээр байх бөгөөд оны төгсгөл рүү тээврийн зардал буурах төлөвтэй.
- IHS Markit байгууллагаас зарладаг **Евро бүсийн PMI<sup>1</sup>** индекс 8-р сард 59.5 гарсан нь **бизнесийн идэвхжил эрчтэй нэмэгдэнийг** илтгэж байна. Ажил олголт сүүлийн 21 жилийн дээд түвшинд хүрч, эрэлт нийлүүлэлтээс давж өссөн тул компаниудын зардал, үнэ сүүлийн 20 жилд гараагүйгээр хурдтай өсчээ. Тээвэрлэлттэй холбоотой нийлүүлэлтийн гинжин сүлжээ саатсанаас аж үйлдвэрлэлийн орц, эд анги хомсдож, боловсруулах салбарын PMI 59.2 буюу сүүлийн 6 сарын доод түвшинд хүрэв. Харин үйлчилгээний

салбарын PMI 59.7 хүрч, цар тахал гарснаас хойш анх удаа аж үйлдвэрлэлийн өсөлтийг давлаа.

- **БНСУ-ын төв банк** цар тахал дэгдсэнээс хойш **бодлогын хүүгээ өсгөсөн** Азийн анхны төв банк боллоо. Тус төв банк 8-р сарын 19-ний мөнгөний бодлогын хурлаар бэнчмарк хүүг 0.25 нэгж хувиар өсгөж 0.75 хувьд хүргэжээ. Энэ нь 2018 оны 9-р сараас хойш анх удаа хүүг өсгөж буй шийдвэр юм. Цар тахлын үед төсвийн дэмжлэг үргэлжилж байгаа хэдий ч хэрэглээ төдийлөн нэмэгдэхгүй байгаа бөгөөд орон сууцны үнэ 7-р сард жилийн 14.3 хувиар өссөн нь санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзсэн тул ийнхүү бодлогын арга хэмжээ авчээ. Мөн ОХУ, Унгар, Чех зэрэг Европын төв банкууд 7,8-р сард бодлогын хүү өсөх шийдвэр гаргаад байна.

#### Эх сурвалж:

1. The Conference Board, [Global Economic Outlook - August 2021](#)
2. Atradius, [Global Economic Outlook - August 2021](#)
3. Financial Times, [South Korea becomes first big Asian economy to raise interest rates](#)
4. Financial Times, [Coronavirus: Pentagon to mandate Covid vaccination for US military - as it happened](#)
5. McKinsey, [COVID-19: Briefing note #71, September 8, 2021](#)
6. McKinsey, [What's going on with shipping rates?](#)

<sup>1</sup> PMI буюу Худалдан авалтын менежерийн индекс нь үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын идэвхжил хөдөлгөөний чиглэлийг хэмждэг индекс юм. 50-с

дээш утга нь өсөлтийг илтгэх бөгөөд, тоо нь өндөр байх тусам өсөлт хурдан байгааг илтгэнэ.

*Эдийн засгийн голлох индексүүдийн өөрчлөлт*

- **БНХАУ-ын 7-р сарын статистик мэдээ зарлагдсан нь хүлээлтээс доогуур байв.** Тухайлбал жижиглэн худалдаа өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар, үйлдвэрлэлийн гарц 6.4 хувиар буурсан бол ажилгүйдлийн түвшин өнгөрсөн сараас 0.1 нэгж хувиар өсөж 5.1 хувьд хүрчээ. Үүнээс шалтгаалан хувийн хэрэглээ буурч байгаа тул БНХАУ-ын Ардын банк бодлогын хүүгээ бууруулахаас илүүтэйгээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулж, заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулах төлөвтэй байна.
- **Үйлдвэрлэлийн PMI 7-р сарын байдлаар 50.4, өмнөх сараас 0.5-аар буурчээ.** Харин урьдчилсан тооцоогоор 8-р сарын үйлдвэрлэлийн PMI 50.2 болж буурахаар байна.
- Инфляц 7-р сард өмнөх оны мөн үеэс 1 хувиар, Үйлдвэрлэлийн инфляц 9 хувиар тус тус өссөн байна. Түүнчлэн, 7-р сарын экспорт өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар, импорт 28.1 хувиар өслөө. БНХАУ-ын үйлдвэрлэлийн гарц 7-р сард муудахад БНХАУ-ын Хэнан мужид нэг жилд орох борооны хэмжээтэй дүйцэхүйц 3 өдөр үргэлжилсэн аадар бороо нь үерийн аюултай нөхцөлд хүргэсэн болон компьютерын чипний хомсдолтой холбоотой байв.
- БНХАУ-ын Бодлого Шинжлэх Ухааны Холбооны Эдийн засгийн бодлогын хорооны дэд захирал Сю Хунцай: **Эдийн засгийн сэргэлтэд үзүүлэх цар тахлын сөрөг нөлөө төсөөллөөс өндөр байгаагаас банкны сектор дахь муу зээлийн хэмжээ нэмэгдэж байна.**

Иймээс эрх баригчдын зүгээс нэмэлт бодлогын арга хэмжээг авах зайлшгүй шаардлага үүсээд буйг мэдээллээ. Түүнчлэн, дельта вирусийн тархалт БНХАУ-д энэ оны 7-р сарын дунд үеэс бүртгэгдсэн нь макро эдийн засгийн үзүүлэлтүүд муудахад нөлөөлж байгаа бөгөөд цаашид энэ нөхцөл үргэлжлэхийг шинжээчид анхааруулж байна.

*Ган, коксжих нүүрсний импорт, эрэлт, нийлүүлэлт*

- БНХАУ-ын дотоодын нүүрсний нийлүүлэлт 8-р сард өмнөх сараас бага зэрэг сайжирсан хэдий ч 2020 оны мөн үетэй харьцуулахад 12.4 хувиар буурсан байна. Түүнчлэн тус улсын импортын нүүрсний нийлүүлэлт буурсан бөгөөд эрэлт өндөр байгаагаас 1 тонн нүүрсний хилийн үнэ 8-р сарын 20-ны байдлаар 229 ам.долларт хүрч өссөн тухай Sxcoal мэдээллээ.
  - БНХАУ цар тахалтай холбоотойгоор хил, боомтын хөл хорионы дэглэмийг чангатгаснаар 8-р сарын байдлаар 100 орчим усан онгоц зогсоолоо хүлээж гацсан нь нүүрсний усан тээврийн үнэ өсөхөд голлон нөлөөлөв.
  - 2021 оны 7-р сарын 15, 8-р сарын 14-ний өдрүүдэд Чинхай дахь Шаанси болон Баруун тэнгисийн нүүрсний уурхайд үер усны аюулаас шалтгаалан нуралт үүсч 25 хүн нас баржээ. Үүнээс шалтгаалан уурхайн аюулгүй байдлын улсын захиргаанаас нийт нүүрсний уурхайд үер болон нуралтаас сэргийлэх системд шалгалт хийж эхлээд байна.
- Монголын нүүрсний нийлүүлэлт*
- Монголын нүүрсний экспорт цар тахлаас шалтгаалан буурч Цагаан хад боомт хүртэлх тээвэр зогссон байна. Харин Цагаан хад боомтоос

Гашуунсухайт боомт хүртэлх нүүрсний тээвэр хязгаарлалттай хэвээр бөгөөд 1 ачааны машины тээврийн зардал 15.5 орчим ам.доллараар нэмэгдэж 138-148 ам.долларын хооронд хэлбэлзэж байна.

- БНХАУ Монгол улсаас импортолсон нүүрсийг Хойд бүсээс Зүүн БНХАУ-д хүргэх төмөр замын тээврийн суваг нээсэнтэй холбоотойгоор Эрээн хотыг дамжсан Монголын нүүрсний тээвэр 3

өдөр 2 шөнийн дараа буюу 2021 оны 8-р сарын 14-нд Янжоу дахь олон улсын Луган тээврийн парк дээр анхны 48 чингэлэг бүхий нүүрсийг буулгалаа. Цаашид нүүрсний чингэлэг тээвэр нэмэгдэх хүлээлттэй байна.

**Эх сурвалж:**

1. *China: July Data Dump Suggests Weakening Momentum, Continuum Economics*
2. *Xi holds phone conversation with Putin, XinhuaNet*

3

### МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
Үнэ (\$) 2021/08/24	Өөрчлөлт						
	өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	жилийн		
Зэс	9378	0.8%	1.6%	-4.2%	6.6%	43.7%	Зэсийн үнэ 5-р сард 10470 ам долларт хүрч, 6-р сараас эхлэн тасралтгүй буурсан. Энэ нь зэсийн томоохон хэрэглэгч болох БНХАУ-ын эрэлт муудсан болон цар тахлын тархалт дэлхий даяар эрчимжиж байгаа зэрэг нөлөөлсөн байна. Хамгийн сүүлийн байдлаар БНХАУ-ын 7-р сарын макро үзүүлэлтүүд муудсан болон ХНБ-наас бодлогын хүүгээ өсгөх хугацааг наашлуулах тухай зарласан нь зэсийн үнэ буурахад нөлөөлж болзошгүй байна.
Төмрийн хүдэр	146	3.1%	-7.6%	-26%	-7.4%	23.7%	БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн гарц 7-р сард өмнөх сараас 7.6 хувиар буурсан нь төмрийн хүдрийн эрэлт 7-р сарын дунд үе хүртэл өмнөх сараас 40 хувиар буурахад нөлөөлөв. Эрэлтийг дагаж үнэ 8-р сарын дунд хүртэл буураад байсан ч гангийн үйлдвэрлэл эргээд бага зэрэг сэргэсэн байна. Тухайлбал, 8-р сарын 11-20-ны хооронд 1 өдрийн гангийн үйлдвэрлэл дунджаар 2.14 сая тонн хүрсэн нь сарын эхний 10 хоногийн дундаж хэмжээтэй харьцуулахад 4.6%-иар өссөн гэж БНХАУ-ын төмөр, гангийн ассоциацийн тайланд дурджээ. Энэ нь төмрийн



							хүдрийн үнэ эргээд өсөхөд нөлөөлсөн хэдий ч өмнөх сартай харьцуулахад 26 хувиар буураад байна.
<b>Алт</b>	1802	-0.1%	0.9%	0.3%	5.1%	-3.5%	Хэдийгээр эдийн засаг сэргэж буй боловч дельта вирусын тархалт нэмэгдэж байгаа тул тодорхой бус байдал хадгалагдаж, зарим Төв банкууд алт худалдан авалтаа үргэлжлүүлж байна. Ялангуяа, алтан гулдмайн худалдан авалтаараа Евро бүсдээ тэргүүлэгч Германы алтны худалдан авалт өмнөх 6 сартай харьцуулахад 35 хувиар өслөө. Харин зарим орнуудын худалдан авалт буураад байгаа нь алтны үнэ буурах чиглэлд нөлөөлж байна.
<b>Газрын тос (Брент)</b>	71	3.3%	2.9%	-4.6%	5.2%	69.4%	Газрын тосны үнэ 2020 онд дунджаар 42 ам.доллар байсан бол энэ оны 8-р сарын 24-ний байдлаар 71 ам.долларт хүрч нэмэгдэв. Дэлхийн газрын тосны нийлүүлэлт нэмэгдэж буй хэдий ч дельта вирусийн тархалт нь эрэлтэд нөлөөлж болзошгүй байна.